

Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам

1. Нийтлэг үндэслэл

- 1.1 Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв (цаашид төв гэх) - өөр үйлчлүүлж буй үйлчлүүлэгч, эмчлүүлэгчдэд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ (үзлэг, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, зөвлөгөө, сувилгаа, асаргаа,-)г чирэгдэлгүй, шуурхай, жигд хүртээмжтэй, чанартай, тасралтгүй үзүүлэх үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь үйлчлүүлэгч төвтэй байж, эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх, мэдээлэл солилцох үйл ажиллагааны уялдаа холбоо, шуурхай байдлыг сайжруулан эмнэлгийн тусламж, үйлчилгээний чирэгдлийг бууруулахад чиглэгдэнэ.
- 1.3 Эмнэлгийн тусламж үйлчилгээнд цахим “Өвчний түүх” хөтлөх, онош тавих, оношилгоо шинжилгээний хариу зэрэг эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг монгол хэл дээр бичнэ.
- 1.4 Төв нь тусламж үйлчилгээнд заавал мөрдөх журам, заавар, стандартыг эмнэлгийн мэргэжилтэн бүрд хүртээмжтэй хэмжээгээр тогтмол хангана.
- 1.5 Төвийн удирдлага, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн ажилтнууд энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.
- 1.6 Удирдлагын багийн хамт олон удирдлага арга зүйгээр ханган ажиллана.

2. Поликлиникийн тусламж, үйлчилгээ

- 2.1 Үйлчлүүлэгчдэд 09 цагаас 15 цагийн хооронд, ээлжээр 17 цаг хүртэл үйлчилнэ.
- 2.2 Үйлчлүүлэгчдэд сэтгэцийн эрүүл мэндийн үндсэн болон төрөлжсөн тусламж үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:
 - Сэтгэцийн эрүүл мэндийн үзлэг (урьдчилан сэргийлэх), оношилгоо, шинжилгээ, зөвлөгөө, сургалт
 - Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, зөвлөгөө, эмчилгээ, сургалт
 - Сэтгэцийн архаг эмгэгтэй эмчлүүлэгчдийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, зөвлөгөө, эмчилгээ, байнгын хяналт

- Стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг (сэтгэцийн тулгамдсан асуудал)-тэй хүмүүсийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, зөвлөгөө, эмчилгээ
- Донтох эмгэгийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, зөвлөгөө, эмчилгээ, хяналт
- Хүүхэд, өсвөр үеийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, зөвлөгөө, эмчилгээ, хяналт
- Бэлгийн /сексийн/ эмгэгийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, зөвлөгөө, эмчилгээ
- Сэтгэл заслын эмчилгээ
- Сэтгэл зүйн оношилгоо, шинжилгээ
- Сэтгэц, нийгмийн сэргээн засалтын оношилгоо, зөвлөгөө, эмчилгээ
- Сэргээн засах, физик эмчилгээний эмчийн үзлэг, оношилгоо, зөвлөгөө, эмчилгээ
- Шүд, амны хөндийн амбулаторийн тусламж үйлчилгээ
- Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын үзлэг, оношилгоо, магадлан шинжилгээ
- Сэтгэцийн эрүүл мэндийн 24 цагийн утсаар мэдээлэл өгөх тусламж, үйлчилгээ
- Хуваарилагдсан сэтгэцийн мэргэжлийн эмч нарын Нийслэлийн төвийн дүүргүүдэд сардаа 1 удаа (Пүрэв гарагт) очиж өгөх мэргэжил арга зүйн зөвлөгөө
- Алслагдсан дүүргүүдэд цахимаар өгөх мэргэжил арга зүйн зөвлөгөө
- Орон нутгийг хариуцсан эмчийн мэргэжил арга зүйн цахим болон биечлэн үзүүлэх зөвлөгөө
- Ковшид-19 эмгэгийн оношилгоо, тусламж, үйлчилгээ

23 Поликлиникийн үзлэгийн эмч нь үйлчлүүлэгч, эмчлүүлэгчдийн сэтгэцийн болон биеийн байдлыг үзэж үнэлэх, оношлох (олон улсын өвчний Х ангиллын дагуу), шинжилгээ хийлгэх, эмчилгээг стандарт удирдамжийн дагуу хийх, эмчилгээний үр дүнг хянах, зөвлөгөө өгөх, хяналтад авах, шаардлагатай үед төвийн стационарт болон бусад эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлэхээр илгээнэ.

24 Төвийн стационарт хэвтүүлэн эмчлэх шаардлагатай сэтгэцийн эмгэг /Хавсралт 1/-ийн дагуу эрэмбэлэн ангилалтыг хийж, хуваарилалт /Хавсралт 2/-ын дагуу илгээнэ.

25 Сэтгэцийн болон биеийн байдал хүнд эмгэгтэй эмчлүүлэгчийг үзлэгийн эмч ~~нь~~ Поликлиникийн эрхлэгч, зөвлөх эмч, яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч эмчтэй хамтарсан үзлэг хийж хэвтүүлэн эмчлэх асуудлыг ~~ий~~двэрлэнэ.

- 2.6 Шаардлагатай тохиолдолд эмчлүүлэгчийн биеийн болон сэтгэцийн байдлыг үнэлэх зорилгоор холбогдох шинжилгээ хийж хэвтүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.
- 2.7 Эмчлүүлэгчийг стационарт хэвтүүлэн эмчлэхээс гэр бүл, асран хамгаалагч, харгалзан дэмжигч эрс татгалзсан тохиолдолд “Эмнэлгийн тусламж үйлчилгээ авахаас татгалзсан тухай мэдүүлэг”-ийн хуудас 2 хувийг хөтлөн нэг хувийг өөрсдөд нь өгч, нэг хувийг “Амбулаторийн хяналтын карт”-д хавсаргана.
- 2.8 Сэтгэцийн эмгэгийн улмаас сэтгэцийн эмчийн байнгын хяналтад байх шаардлагатай эмчлүүлэгчийг амбулаторийн идэвхтэй хяналтад авч эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.
- а) Хяналтад авах шаардлага:
- Сэтгэцийн эмгэгийн шинж тэмдгүүд тод илэрсэн
 - Сэтгэцийн эмгэгийн хам шинжүүд үе үе дахих хандлагатай
 - Нийгэмд болон өөртөө аюултай үйлдэл хийж болзошгүй
 - Сэтгэцийн эмгэгийн хам шинжүүд даамжирч байгаа
 - Сэтгэцийн эмгэгийн хам шинжүүд эмчилгээний засрал сайжрал бага
 - Сэтгэцийн эмгэгийн хам шинжүүд даамжран бусдын хараа хяналт шаардлагатай
 - Сэтгэцийн эмгэгийн улмаас өвчний төгсгөлийн үе шатанд орсон байнгын асаргаа шаардлагатай
- б) Амбулаторийн идэвхтэй хяналтад авсан эмчлүүлэгчдийн оношийн дагуу тусгай тэмдэгтэй карт болон хяналтын хуудас нээнэ.
- в) Хяналтын үзлэгийг сэтгэцийн эмгэгийн явцаас хамаарч өдөр, сар, улирал болон ирэх бүрд үзлэг хийж цахим тэмдэглэл хөтөлнө.
- г) Хяналтад ирж үзүүлэх хугацааг эмч тогтооно.
- д) Шаардлагатай тохиолдолд эрэмбэлэн ангилалтыг хийж стационарт хэвтүүлэхээр илгээнэ.
- 2.9 Амбулаторийн идэвхтэй хяналтад байгаа эмчлүүлэгчийн сэтгэцийн байдлыг үнэлэн шаардлагатай сэтгэцэд нөлөөт эмийг жороор үнэгүй олгоно. Үнэгүй эмийг олгохдоо эмч нарын хяналтын комиссын шийдвэр гаргуулах ба төрөөс үнэ төлбөргүй олгох эмийн журмыг баримтална.
- 2.10 Амбулаторийн идэвхтэй хяналтад байгаа эмчлүүлэгчдийг даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалтын дагуу хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтооно.

а) Хөдөлмөр чадвар алдалт тогтооход тавигдах шаардлага:

- Амбулаторийн идэвхтэй хяналтад авах шаардлагыг хангасан ба зөвлөх эмчийн үзлэгээр онош тогтоогдож 6 сар ба түүнээс дээш хугацаагаар амбулаторийн идэвхтэй хяналтад байгаа
- Амбулаторийн идэвхтэй хяналтад ороогүй боловч сэтгэцийн эмгэг даамжирч бусдын хараа хяналт байнгын асаргаа шаардлагатай болсон
- Амбулаторийн идэвхтэй хяналтад ороогүй боловч өөр улс оронд сэтгэцийн эмгэгээр оношлогдож удаан хугацааны эмчилгээ хийлгэж засрал сайжралын байдалд байгаа боловч сэтгэцийн эмгэгийн хам шинжүүд үе үе дахидаг
- Оюуны хомсдол эмгэг бага наснаас оношлогдсон
- Оюуны хомсдол эмгэг /Оюуны коэффициентийг үндэслэн/
- Аутизм эмгэгтэй

б) Хөдөлмөрийн чадвар алдалтыг шинээр тогтооход онош, оношийн үндэслэлийг дэлгэрэнгүй хийж зөвлөх эмчийн үзлэгээр баталгаажуулж, сунгуулахад эмчлүүлэгчийн өвчний явцын цахим үзлэгийн тэмдэглэлийг хэвлэн, хяналтын эмч өөрөө хариуцан эмч нарын хяналтын комисс /ВКК/ болон Эмнэлэг хөдөлмөр магадлалын комисс /ВТЭК/-ын хуралд оруулна.

- 2.11 Сэтгэцийн эмгэгтэй эмчлүүлэгчийн үзлэгийг цахимаар хөтөлж “Амбулаторийн хяналтын карт”-д хэвлэсэн хуудсыг хавсаргана.
- 2.12 Ажлын өдөр Поликлиникээр ирсэн биеийн байдал хүнд үйлчлүүлэгчийг “Цахим бүртгэл”-д бүртгэлгүй шууд Яаралтай тусламжийн тасагт илгээнэ.
- 2.13 Үйлчлүүлэгчдэд сэтгэцийн болон эрүүл мэндийн боловсрол олгох, архаг эмгэгийн сэдрэлээс урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээний талаар сургалт, сурталчилгаа явуулна.
- 2.14 Поликлиникийн зарим үзлэгийн эмчийн өрөөнд ашиглагдаж байгаа оношилгооны тоног төхөөрөмжийн техникийн аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлан ажиллаж, тоног төхөөрөмжийн цаг ашиглалтын паспортыг тогтмол хөтлөн баталгаат үзлэгт тогтмол хамруулна.
- 2.15 Эмнэлгээс шалтгаалсан халдвараас урьдчилан сэргийлэх, халдварын сэргийлэлтийг чанд баримтлан ажиллаж, үйлчлүүлэгчид эрүүл аюулгүй орчинд тусламж үйлчилгээ авах бүхий л бололцоо нөхцөлөөр хангаж ажиллана.
- 2.16 Ковид-19 цар тахлын үеийн тусламж үйлчилгээний холбогдох тушаал, журмуудыг чанд мөрдөн ажиллана.

2.17 Поликлиникийн үзлэгийн эмч, мэргэжилтнүүд нь бусдыгаа орлох болон бусад клиник, тасаг, нэгжүүдтэйгээ холбоотой ажиллаж, мэргэжлийн ба бусад үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцоно.

3. Хэвтүүлэн эмчлэх буюу стационарын тусламж, үйлчилгээ

3.1 Үйлчлүүлэгчдэд тусламж, үйлчилгээг 24 цагийн турш үзүүлнэ.

3.2 Үйлчлүүлэгчдэд сэтгэцийн эрүүл мэндийн үндсэн болон төрөлжсөн тусламж үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- Сэтгэцийн эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, зөвлөгөө, сургалт
- Сэтгэцийн эмгэгийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, зөвлөгөө, эмчилгээ, сургалт
- Сэтгэцийн архаг эмгэгийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, зөвлөгөө, эмчилгээ
- Стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг (сэтгэцийн тулгамдсан асуудал) – ийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, зөвлөгөө, эмчилгээ, сургалт
- Донтох эмгэгийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, зөвлөгөө, эмчилгээ, сургалт
- Хүүхэд, өсвөр үеийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, зөвлөгөө, эмчилгээ
- Сэтгэл заслын эмчилгээ
- Сэтгэцийн эмгэгийн үеийн яаралтай тусламж, үйлчилгээ
- Асрамжийн тусламж, үйлчилгээ
- Ковид – 19 халдвартай сэтгэцийн эмгэгтэй хүний оношилгоо, эмчилгээ
- Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээ
- Сэргээн засах, физик эмчилгээ
- Сэтгэл зүйн оношилгоо, шинжилгээ
- Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын үзлэг, оношилгоо, эмчилгээ, магадлан шинжилгээ

3.3 Клиникийн эмч нь эмчлүүлэгчдийн сэтгэцийн болон биеийн байдлыг үзэж үнэлэх, оношлох (олон улсын өвчний X ангиллын дагуу), шинжилгээ хийлгэх, эмчилгээг стандарт удирдамжийн дагуу хийх, эмчилгээний үр дүнг хянах, зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

3.4 Стационарт хэвтүүлэн эмчлэх заалт

3.4.1 Сайн дурын эмчилгээ – Үйлчлүүлэгч өөрөө хэвтэн эмчлүүлэх хүсэлт тавьсан байх ба одоогийн сэтгэцийн байдал, илэрч буй хам шинжээр эрэмбэлж;

- 3.4.2 Албадлагын эмчилгээ - Өөртөө болон бусдад, нийгэмд хохирол учруулах магадлал бүхий сэтгэцийн эмгэгийн хам шинжтэй, сайн дураараа хэвтэхээс татгалзаж байгаа үйлчлүүлэгчийг нийгэмд аюултай үйлдэл хийхээс урьдчилан сэргийлж; (ЭМС-ын баталсан “Албадан хэвтүүлж эмчлэх шаардлагатай сэтгэцийн эмгэгийн жагсаалт”-ыг баримтална)
- 3.4.3 Албадан эмчилгээ – хуулийн эрх бүхий байгууллагын тогтоолоор;
- 3.4.4 Ковид – 19 халдварын эмчилгээ - Антигенд суурилсан түргэвчилсэн сорил, бодит хугацааны ПГУ-ын шинжилгээгээр Ковид – 19 халдвар баталгаажсан сэтгэцийн эмгэгтэй эмчлүүлэгч; (ЭМС-ын баталсан “Тандалт халдварын, сэргийллээс хяналт, хариу арга хэмжээ, оношилгоо эмчилгээний түр заавар”-ыг баримтална)

4 Өдрийн эмчилгээ

- 4.1 Донтох эмгэгийн эмчилгээ (Ор хоног: 8-10)
- 4.2 Донтох эмгэгийн зөвлөгөө, эмчилгээ, сургалт (Ор хоног: 18-21)
- 4.3 Стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэгийн эмчилгээ (Ор хоног: 7-9)
- 4.4 Сэргээн засах эмчилгээ (ор хоног - 5)
- 4.5 Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээ (Ор хоног - 21)

5 Эмнэлэгт эмчлүүлэгч хүлээн авах

- 5.1.1 Стационарт хэвтэн эмчлүүлэхээр ирсэн эмчлүүлэгчийг эмнэлэгт өвчтөн илгээх хуудас /СЭМҮТ-ийн поликлиник, аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвийн сэтгэц-наркологиын кабинет, яаралтай тусламжийн /103/ сэтгэцийн эмчийн бичиг/, иргэний үнэмлэх зэргийг үндэслэн, ажлын өдрүүдэд ажлын цагаар хүлээн авах тасгийн эмч, сувилагч, амралтын болон ажлын өдрүүдэд ажлын бус цагаар жижүүрийн эмч, сувилагч эмчлүүлэгчийг хүлээн авч, сэтгэцийн болон биеийн байдлыг үзэж үнэлэн хэвтүүлэн эмчлэх заалтын дагуу эрэмбэлэн ангилж, яаралтай тусламжийг хуудсыг бөглөн, цахим “Өвчний түүх”-ийг нээж, холбогдох клиникт хэвтүүлж шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- 5.1.2 Стационарт хэвтэхээр өөрсдөө ирсэн биеийн байдал хүнд эмчлүүлэгчийг ажлын өдрүүдэд ажлын цагаар хүлээн авах, яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч эмч нь зөвлөх эмч болон холбогдох төрөлжсөн клиникийн эрхлэгч эмчтэй хамтарсан үзлэгийг хийж хэвтүүлэн эмчлэх асуудлыг шийдвэрлэнэ.
- 5.1.3 Сэтгэцийн болон биеийн байдал хүнд эмгэгтэй эмчлүүлэгчийг амралтын болон ажлын өдрүүдэд ажлын бус цагаар жижүүрийн эмч нар хамтран

хамтарсан үзлэгийг хийж хэвтүүлэн эмчлэх асуудлыг шийдвэрлэх ба Нэгдүгээр жижүүрийн эмч ахална.

- 5.1.4 Эмчлүүлэгчийг эмнэлэгт хэвтүүлээгүй тохиолдолд эмч үзлэг хийж, сэтгэцийн болон биеийн байдлыг үнэлэн эрэмбэлэн ангилалт хийж, яаралтай тусламжийн хуудас хөтлөх ба энэ тухайгаа “СЭМ-ийн тусламж, үйлчилгээний мэдээний буцаасан тэмдэглэл” хэсэгт авсан арга хэмжээ, үзүүлсэн тусламж, гаргасан шийдвэрийн хамт дэлгэрэнгүй тэмдэглэж үлдээнэ.
- 5.1.5 Сэтгэцийн өөрчлөлттэй эмчлүүлэгчийг эмнэлэгт хэвтүүлэн эмчлэхээс гэр бүл, асран хамгаалагч, харгалзан дэмжигч эрс татгалзсан тохиолдолд “Эмнэлгийн тусламж үйлчилгээ авахаас татгалзсан тухай мэдүүлэг” –ийн хуудас 2 хувийг хөтлөн нэг хувийг өөрсдөд нь өгч, нэг хувийг авч үлдээн ЯТТ-т хадгална.
- 5.1.6 Эмчлүүлэгчийг хүлээн авах тасагт бүх биеийн үзлэг хийж, шаардлагатай тохиолдолд нийгэмд болон өөртөө аюултай үйлдэл хийж болзошгүй сэтгэцийн эмгэгтэй хүнд урьдчилан сэргийлэх зорилгоор тусгаарлах болон номхотгох аргыг хэрэглэнэ. (ЭМС-ын баталсан журмыг баримтална)
- 5.1.7 Ковид-19 халдвартай сэтгэцийн эмгэгтэй эмчлүүлэгчийн антигенд суурилсан түргэвчилсэн сорил бүхий шинж тэмдэгтэй болон бодит хугацааны ПГУ-ын шинжилгээгээр баталгаажсан хариуг үндэслэн хэвтүүлэн эмчлэх заалтын дагуу (биеийн байдал хөнгөн, хүндэвтэр хүчилтөрөгчийн хэрэгцээ шаардлагагүй) эрэмбэлэн ангилж, яаралтай тусламжийн хувдсыг бөглөж, “Сэтгэц Ковид -19” тасагт хэвтүүлнэ. Биеийн байдал хүнд, нэн хүнд хүнийг яаралтай тусламж үзүүлэн, харьяа эмнэлэгт шилжүүлнэ.
- 5.1.8 Ковид-19 халдвартай сэтгэцийн эмгэгтэй эмчлүүлэгчийн сэтгэцийн болон биеийн байдлыг үзэхдээ СЭМҮТ-ийн поликлиникээс илгээгдсэн бол тухайн үзсэн эмчийн тэмдэглэл, бусад газрын хариу арга хэмжээний багаас ирсэн бол эмчийн үзлэгийн тэмдэглэл, бусад эмнэлгээс шилжин ирсэн бол эмчийн үзлэгийн тэмдэглэл, шилжүүлэх дүгнэлт зэргийг тусгана.
- 5.1.9 Ковид-19 халдвартай сэтгэцийн эмгэгтэй эмчлүүлэгчийг үзэхдээ хүн хоорондын зайг баримтлан халдвар хамгааллын дэглэмийг сайтар мөрдөнө.

5.2 Эмнэлгээс эмчлүүлэгчийг гаргах

- 5.2.1 Эмчлүүлэгчийн сэтгэц эмгэгийн хам шинж арилж эдгэрсэн, эсвэл намжмал байдалд орсон тохиолдолд эмчлэгч эмчийн зөвшөөрлөөр эмнэлгээс гаргах

бөгөөд ар гэр, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт хүлээлгэн өгч, гарын үсэг зуруулж баталгаажуулна.

- 5.2.2 Эмчлүүлэгчийг эмнэлгээс гаргахад нь үндсэн болон хавсарсан өвчний талаар иж бүрэн заавар, зөвлөмжөөр ханган, цаашид баримтлах дэглэм, заавар, зөвлөмж, үргэлжлүүлэн авах тусламж, үйлчилгээ, эмнэлгээс гаргах үеийн дүгнэлтийг “Эмнэлгээс гаргагчийн хуудас”-т тэмдэглэж өгнө.
- 5.2.3 Сэтгэцийн эмгэгийн хяналтыг сайжруулж, эмнэлэгт давтан хэвлэлтийг бууруулах зорилгоор эмнэлгээс гарсны дараах эмчилгээг үргэлжлүүлэх, хянах, болзошгүй хүндрэлээс сэргийлэх, архаг өвчний намжмал байдлыг уртасгах чиглэлээр заавар, зөвлөмжийг заавал ар гэр болон асран хамгаалагчид өгч эмнэлгээс гаргана.
- 5.2.4 Стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын клиник, яаралтай тусламжийн тасгийн эмчлүүлэгч эмчилгээнээс татгалзаж хугацаанаас өмнө эмнэлгээс гарсан тохиолдолд клиникийн эрхлэгч эмчийн зөвшөөрлөөр “Өөрийн хүсэлтээр эмнэлгээс гарах тухай хүсэлт” бичүүлж эмнэлгээс гаргана.
- 5.2.5 Ковид – 19 халдвартай сэтгэцийн эмгэгтэй эмчлүүлэгчийн сэтгэцийн болон биеийн байдал сайжирсан бол шууд эмнэлгээс гаргаж, сэтгэцийн байдал засрал сайжралын байдалд ороогүй тохиолдолд харьяа клиникт эмчилгээг үргэлжлүүлэхээр шилжүүлнэ.
- 5.2.6 Эмчлүүлэгч нас барсан тохиолдолд эмчлэгч эмч төгсгөлийн дүгнэлтийг бичиж, эмгэг судлалын шинжилгээнд оруулах эсэх асуудлыг Эмчилгээ эрхэлсэн дэд захиралтай зөвшилцөж шийдвэрлэнэ. (ЭМС-ын болон СЭМҮТ-ийн ЕЗ-ын тушаалыг баримтална)

5.3 Эмчлүүлэгчийг шилжүүлэх

5.3.1 Эмнэлэг дотор шилжүүлэх

- 5.3.1.1 Эмчлүүлэгчийн одоогийн сэтгэцийн байдал, эмнэлзүйн онош зэргийг үндэслэн харьяаллын болон төрөлжсөн клиникт шилжүүлэх дүгнэлт /эпикриз/-ээр шилжүүлнэ.
- 5.3.1.2 Клиникээс яаралтай тусламжийн тасагт эмчлүүлэгчийг шилжүүлэхдээ зөвлөх эмч, клиникийн эрхлэгч эмч, яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч эмч нартай хамтарсан үзлэг хийж, зөвшилцсөний үндсэн дээр шилжүүлнэ.

- 5.3.1.3 Яаралтай тусламжийн тасгаас сэтгэцийн болон биеийн байдал нь сайжирсан тохиолдолд яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч эмчийн шийдвэрээр шилжүүлнэ.
- 5.3.1.4 Идэвхтэй хэлбэрийн, шинжилгээний үзүүлэлт эерэг сүрьеэ өвчтэй нь оношлогдсон эмчлүүлэгчийг сүрьеэгийн үзлэгийн эмчийн зөвшөөрлөөр “Асрамжийн клиник”-т шилжүүлнэ.
- 5.3.1.5 Сэтгэцийн архаг эмгэгтэй, гэр оронгүй, асран хамгаалагч байхгүй эмчлүүлэгчийг Эмчилгээ эрхэлсэн дэд захирлын албан бичгээр “Асрамжийн клиник”-т шилжүүлнэ.
- 5.3.1.6 Антигенд суурилсан түргэвчилсэн сорил бүхий шинж тэмдэгтэй болон бодит хугацааны ПГУ-ын шинжилгээгээр Ковид-19 халдвартай нь батлагдсан сэтгэцийн эмгэгтэй эмчлүүлэгчийг “Сэтгэц Ковид - 19” тасагт шилжүүлэн эмчилнэ.

5.3.2 Эмнэлэг хооронд шилжүүлэх

- 5.3.2.1 Эмчлүүлэгчийг өөр бусад эмнэлэгт шилжүүлэх тохиолдолд эмчлэгч эмч эмчлүүлэгчийн тухай мэдээлэл бүхий 13А маягтыг бичиж эмчилгээ эрхэлсэн дэд захирлаар баталгаажуулан шилжүүлнэ. Уг маягтад багтахгүй мэдээллийг /шинжилгээний хариу, хийгдсэн эмчилгээ, хийгдсэн гардан үйлдэл/ тусад нь өөр цаасан дээр бичнэ.
- 5.3.2.2 Өөр эмнэлэгт шилжүүлэхдээ эмчлэгч эмч өөрөө хүргэж өгнө.
- 5.3.2.3 Амралт болон ажлын өдрүүдэд ажлын бус цагаар эмчлүүлэгчийг өөр бусад эмнэлэгт шилжүүлэх тохиолдолд хоёрдугаар жижүүрийн эмч хүргэж өгөх ба нэгдүгээр жижүүрийн ахлах эмч нь мэргэжил арга зүйгээр заавал хангана.
- 5.3.2.4 Эмнэлэг хооронд зөөвөрлөх боломжгүй, эсхүл тусгай хамгаалалттай нөхцөлд эмчлүүлж байгаа эмчлүүлэгчид цахим зөвлөгөө, телемедициний сүлжээг ашиглан төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж ажиллана.

5.4 Эмчийг томилох

- 5.4.1 Клиникийн эрхлэгч эмч нь эмчлүүлэгчийн эмчлэгч эмчийг томилно.
- 5.4.2 Эмчлүүлэгчийг клиникт хэвтмэгц, эмчлэгч эмч эмчлүүлэгчийн цаашдын оношилгоо, эмчилгээг бүрэн хариуцна.
- 5.4.3 Эмчлүүлэгч хоног болоогүй, хоног болсон боловч үндсэн клиникээс эмчлэгч эмч томилогдож амжаагүй нас барсан тохиолдолд хамгийн сүүлд үзэж байсан эмч нь эмчлэгч эмч болох бөгөөд эмгэг судлалын шинжилгээний

асуудлыг нь хариуцна. Үүнд: шарилыг зөв хадгалах, задлан шинжилгээнд орох г м.

- 5.4.4 Бусад тусгай мэргэжлийн төрөлжсөн төв эмнэлэг болон үндсэн мэргэжлийн эрүүл мэндийн төв болон амаржих газарт батлагдсан хуваарийн дагуу эмч нарыг эмчилгээ эрхэлсэн дэд захирал томилсон (Эмчилгээ эрхэлсэн дэд захирлын орлож буй хүн томилж болно) – оор тусламж үйлчилгээг үзүүлнэ. Хэрхэн тусламж үйлчилгээ үзүүлсэн тухайгаа эргэн Эмчилгээ эрхэлсэн дэд захиралд мэдэгдэх бөгөөд дэвтэрт тэмдэглэл хөтөлж гарын үсгээр баталгаажуулна.
- 5.4.5 Цар тахал бүхий халдварт өвчин, гэнэтийн гамшиг, олныг хамарсан осол болон орон нутагт үзлэг, шинжилгээ хийх шаардлага гарсан тохиолдолд мөн алсын дуудлага зэрэгт эмчилгээ эрхэлсэн дэд захирлын томилсноор сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.
- 5.4.6 Клиникт эмчлүүлж байгаа эмчлүүлэгчийн сэтгэцийн болон биеийн байдал хүндэрч эмчлүүлэгчийн оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, цаашид авах арга хэмжээг шийдвэрлэх үед Зөвлөх эмч, Эрхлэгч эмч байхгүй тохиолдолд Эмчилгээ эрхэлсэн дэд захирал, бусад эмч нараас хамтарсан үзлэг хийлгэхээр томилно.
- 5.4.7 *Эмнэлэгт албадан хэвтүүлсэн эмчлүүлэгчийн сэтгэцийн байдал нь албадан хэвтүүлэх заалттай тохирч байгаа эсэхийг магадлан тогтоох комисс нь магадлан тогтоох журмыг баримтлан ажиллана.*

5.5 Эмч нарын хамтарсан үзлэг хийх

- 5.5.1 Сэтгэцийн болон биеийн байдал хүнд эмчлүүлэгчийн оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, цаашид авах арга хэмжээг шийдвэрлэх зорилгоор хэвтсэн хугацаа харгалзахгүйгээр эмч нарын хамтарсан үзлэгийг 3 ба түүнээс дээш эмч нарын бүрэлдэхүүнтэйгээр хийнэ.
- 5.5.2 Клиникт удаан хугацаагаар хэвтэн эмчлүүлж байгаа үед биеийн байдал хүндрэх, сэтгэцийн байдал хурцадсан тохиолдолд тухайн клиникийн эмч нар эрхлэгч эмчээр ахлуулсан хамтарсан үзлэг заавал хийнэ.
- 5.5.3 Амралтын болон ажлын өдрүүдэд ажлын бус цагаар стационарт хэвтэн эмчлүүлж буй эмчлүүлэгчийн сэтгэцийн болон биеийн байдал хүндэрсэн тохиолдолд жижүүрийн хоёр эмч хамтарсан үзлэгийг хийж, оношилгоо эмчилгээний асуудлыг шийдвэрлэх ба нэгдүгээр жижүүрийн эмч ахална.
- 5.5.4 Эмчлэгч эмч эмчлүүлэгчийн сэтгэцийн болон биеийн байдлын тухай, клиникийн эрхлэгч эмч (эрхлэгч эмч байхгүй тохиолдолд эмчилгээ эрхэлсэн

дэд захирал) - д танилцуулж, клиникийн эрхлэгч, зөвлөх эмч (хавсралт) - ийн хамтарсан үзлэг хийнэ.

- 5.5.5 Эмчлэгч эмч, эмч нарын хамтарсан үзлэг хийхийн өмнө өвчний болон амьдралын түүхийн асуумж, холбогдох шинжилгээг бүрдүүлнэ.
- 5.5.6 Эмч нарын хамтарсан үзлэгийг цаг тухайд нь түргэн шуурхай хийх ба хамтарсан үзлэгийн үр дүнд шийдвэр гаргаж цахим “Өвчний түүх”-нд дэлгэрэнгүй тэмдэглэл хийнэ.
- 5.5.7 Клиникийн эрхлэгч эмч өөрөө эмчлэгч эмч бол Эмчилгээ эрхэлсэн дэд захирал, Зөвлөх эмчийн хамт хамтарсан үзлэгийг хийнэ.
- 5.5.8 Зөвлөх эмч, эрхлэгч эмч байхгүй тохиолдолд Эмчилгээ эрхэлсэн дэд захиралд мэдээлж орлох эмчийг томилуулан хамтарсан үзлэгийг хийнэ
- 5.5.9 Ноцтой хүндрэл гарах эрсдэлтэй, хүнд, маш хүнд өвчтөний оношилгоо эмчилгээний асуудлыг шийдвэрлэх шаардлагатай тохиолдолд бусад төрөлжсөн мэргэшлийн зөвлөх эмч нараас зөвлөгөө авч хамтран ажиллана. Шаардлагатай тохиолдолд эмнэлзүй-эмгэг судлалын зөвлөгөөн зохион байгуулж болно.
- 5.5.10 Ковшид-19 халдвартай хавсарсан эмгэгтэй, биеийн байдал хүнд эмчлүүлэгчийн оношилгоо эмчилгээг ЭМС-ын тушаалаар батлагдсан “Зөвлөх баг” -аас зөвлөгөө авч шийдвэрлэнэ.

5.6 Эмч, эмнэлгийн мэргэжилтэн дуудах

5.6.1 Стационарт эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан дуудах

- 5.6.1.1 Клиникт хэвтэн эмчлүүлж буй эмчлүүлэгчдийн биеийн байдал хүндэрсэн тохиолдолд оношилгоо, шинжилгээ хийх зорилгоор амралтын өдөр болон ажлын өдөр ажлын бус цагаар өөрийн эмнэлгийн эмэгтэйчүүд дүрс оношилгооны эмч, лаборант, жолоочийг дуудаж ажиллуулна.
- 5.6.1.2 Эмч, эмнэлгийн мэргэжилтэн дуудан ирүүлэх шийдвэрийг жижүүрийн эмч нар хамтран гаргах бөгөөд жижүүрийн нэгдүгээр ахлах эмч энэ тухайгаа “Дуудлага бүртгэх дэвтэр”-т тодорхой бичиж тэмдэглэнэ.
- 5.6.1.3 Дуудагдсан ажилтнаар гарын үсгийг нь зуруулж баталгаажуулах ба дуудагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, лаборант, жолоочийн ирэх, буцах замдаа зарцуулсан цагийг ажилласан цагт нь оруулан тооцно.

5.6.2 Бусад төрөлжсөн мэргэжлийн эмч дуудах

- 5.6.2.1 Эмчлүүлэгчдэд нарийн төвөгтэй оношилгоо, эмчилгээний асуудлыг цаг алдахгүй, зөв шийдвэрлэх зорилгоор бусад мэргэшлийн чиглэлээр

төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг (хавсралт)-ээс лавлагаа мэргэжил арга зүйн дэмжлэг авч хамтран ажиллана.

- 5.6.2.2 Клиникт хэвтэн эмчлүүлж буй эмчлүүлэгчдэд бусад төрөлжсөн мэргэжлийн эмчид үзүүлэх, оношилгоо, шинжилгээ хийлгэх, зөвлөгөө авах тохиолдолд эмчлэгч эмч, эмчилгээ эрхэлсэн дэд захиралд өөрийн биеэр танилцуулан “Эмч дуудах хуудас”-ыг бичиж, тусламж үйлчилгээ үзүүлнэ.
- 5.6.2.3 Эмчид үзүүлэхээр эмчлэгч эмч өөрөө авч явах бөгөөд туслах сувилагчийн хамт явна.
- 5.6.2.4 “Эмч дуудах хуудас”-д зөвлөгөө авсан ба өгсөн эмчээр хоёулангаар нь гарын үсгийг нь зуруулж, цаг, минутыг нь тэмдэглэж, санхүүгийн баримт болгон өгнө.

5.7 Яаралтай тусламж, үйлчилгээ

- 5.7.1 Яаралтай тусламж шаардлагатай үйлчлүүлэгчдийг ажлын болон ажлын бус өдрүүдэд шууд Яаралтай тусламжийн тасагт хүлээн авч, эрэмбэлэн ангилалтыг хийж, анхны тусламжийг үзүүлнэ.
- 5.7.2 Шаардлагатай тохиолдолд зөвлөх эмчтэй хамтарсан үзлэг хийж шийдвэрийг гаргана. (Төрөлжсөн тусламжийн эмнэлэг, төвүүдэд илгээж болно)
- 5.7.3 Өвчний оношийг богино хугацаанд тогтоох боломжгүй, үйлчлүүлэгчийн биеийн байдал нь эмнэлгийн нөхцөлд ажиглалт болон эмчилгээ хийх шаардлагатай, түүнчлэн ажлын бус цагаар ирсэн нэр, хаяггүй, баримт бичгийн бүрдэлгүй зэрэг үйлчлүүлэгчийг Яаралтай тусламжийн тасгийн Эрчимт эмчилгээний өрөөнд шилжүүлж ажиглах, онош тодруулах, эмчилгээ хийж, шийдвэр гаргасны дараа шилжүүлэх арга хэмжээ авна.
- 5.7.4 Клиникт хэвтэн эмчлүүлж буй биеийн байдал хүндэрсэн, эрчимт эмчилгээ шаардлагатай эмчлүүлэгчдийг шилжүүлэн авч эмчилнэ.
- 5.7.5 Эмчлүүлэгчийн онош тодруулах шаардлагатай тохиолдолд лабораторийн болон багажийн шинжилгээг шуурхай (2-4 цагийн дотор) хийж, шаардлагатай төрөлжсөн мэргэжлийн эмч нарыг дуудан зөвлөгөө авна.
- 5.7.6 Ковид – 19 халдвар болон Халдварт өвчний сэжиг илэрсэн, оношлогдсон тохиолдолд эмчлүүлэгчийг тусгаарлаж, халдварын сэргийлэл, хяналтын арга хэмжээг авч, "Халдварт өвчнийг мэдээлэх хуудас"-ын дагуу мэдээлж, цаг тухай бүрд асуудлыг шийдвэрлэнэ.

5.8 Шүүхийн сэтгэцийн эмгэгийн тусламж, үйлчилгээ

- 5.8.1 Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникт хуулийн эрх бүхий байгууллагын тогтоолтой эмчлүүлэгчийг хүлээн авч эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.
- 5.8.2 Эмчлүүлэгчийн сэтгэцийн болон биеийн байдлыг амралтын өдөр болон ажлын өдөр ажлын бус цагаар ээлжийн сувилагч, туслах сувилагч нар тасралтгүй хараа хяналт тавьж үнэлнэ.
- 5.8.3 Эмчлүүлэгчийн сэтгэцийн байдал хурцдах, биеийн байдал хүндэрсэн тохиолдолд цаг алдалгүй яаралтай эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.
- 5.8.4 Амралтын болон ажлын өдөр ажлын бус цагаар жижүүрийн эмч нар үзлэг хийж эмнэлгийн тусламжийг үзүүлнэ.
- 5.8.5 Биеийн эмгэгээр өвчилсөн тохиолдолд харьяаллын дагуу төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгт цагдаагийн хамгаалалтын дор хэвтүүлэн эмчлэх бөгөөд хяналтын прокурор болон эргүүл хамгаалалтын газрын эргүүлийн тусгай хамгаалалтын хэлтэст заавал мэдэгдэнэ.
- 5.8.6 Албадан эмчилгээ цуцлах тохиолдолд эмчлэгч эмч оношийн үндэслэлийг дэлгэрэнгүй хийж албадан цуцлах тухай саналаа Нийслэлийн прокурорын газрын шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаанд хяналт тавих хэлтэст илгээж, шинжилгээ томилсон тогтоолын дагуу шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлан шинжилгээ хийж, дүгнэлт гарсны дараа шүүхийн шийдвэрээр цуцлах арга хэмжээг авна.

4. Асрамжийн клиникийн тусламж, үйлчилгээ

- 4.1 Сэтгэцийн архаг, байнгын асаргаатай болон идэвхтэй хэлбэрийн, шинжилгээний үзүүлэлт эерэг сүрьеэ эмгэгээр оношлогдсон эмчлүүлэгчдэд тусламж үзүүлнэ.
- 4.2 СЭМҮТ-ийн клиникт удаан хугацаагаар хэвтэн эмчлүүлж буй сэтгэцийн архаг эмгэгтэй эмчлүүлэгчдийг дараах бичиг баримтыг үндэслэн шилжүүлнэ. Үүнд:
- Хууль ёсны асран хамгаалагчийн тухайн эмчлүүлэгчийг асран хамгаалахаас татгалзсан хүсэлт гаргасан өргөдөл
 - Харьяа дүүрэг засаг захиргааны асран хамгаалагчгүйг тодорхойлсон тодорхойлолт
 - Сэтгэцийн эмгэгийн улмаас олон жил мэргэжлийн эмчийн хяналтад байх хугацаанд асран хамгаалагчгүй болсон тухай тодорхойлолт
 - Өвчний олон улсын ангиллын оношийн шалгуураар онош тодорхой болсон

- Сэтгэцийн эмгэгийн улмаас олон жил тасралтгүй эмчлүүлсэн, өөрөө бие даан амьдрах чадваргүй болсныг тодорхойлсон дүгнэлт бүхий эмч нарын болон зөвлөх эмчийн хамтарсан үзлэг
- 4.3 Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн клиникүүдэд хэвтэн эмчлүүлэх хугацаанд сүрьеэ өвчин оношлогдож, сүрьеэгийн эмэн эмчилгээ шаардлагатай эмчлүүлэгчийг шилжүүлнэ. Үүнд:
- Идэвхтэй хэлбэрийн, шинжилгээний үзүүлэлт эерэг сүрьеэ өвчтэй нь сүрьеэгийн эмчийн үзлэгээр онош тогтоогдсон эмчилгээ шаардлагатай бол эмчлэгч эмч, клиникийн эрхлэгч эмч нарын хамтарсан үзлэгээр шийдвэрлэнэ.
 - Сүрьеэгийн эмчилгээ дууссаны дараа эмчлүүлэгчийн сэтгэцийн байдал сайжраагүй тохиолдолд харьяа клиникт буцаан шилжүүлнэ.
 - Сэтгэцийн байдал сайжирсан, сүрьеэгийн эмчилгээ дууссан тохиолдолд эмчлүүлэгчийг анхан болон үндсэн мэргэжлийн эмчийн хяналтад шилжүүлэх буюу эмнэлгээс гаргана.
- 4.4 Сэтгэц хөдөлгөөний догшролд орж, сэтгэцийн эмгэгийн улмаас өөртөө болон бусдад аюултай үйлдэл хийж болзошгүй эмчлүүлэгчийг эмчлэгч эмч, клиникийн эрхлэгч, зөвлөх эмч нарын хамтарсан үзлэгийг хийж, харьяа сэтгэцийн эмгэг судлалын клиникт сэтгэцийн байдал сайжиртал түр хугацаагаар шилжүүлнэ.
- 4.5 Асрамжийн клиникээс сэтгэц хөдөлгөөний догшролд орж, сэтгэцийн эмгэгийн улмаас өөртөө болон бусдад аюултай үйлдэл хийж болзошгүй тохиолдлоос бусад эмчлүүлэгчийг сэтгэцийн эмгэг судлалын клиникт шилжүүлэхгүй.
- 4.6 Асрамжийн клиникт гаднаас эцүүлэгчийг шууд хэвтүүлэн эмчлэхгүй.


5 Бусад

- 5.1 Сэтгэцийн эмч нар нь цахим “Сэтгэцийн өвчний түүх” –ийг бүрэн гүйцэд хөтөлнө.
- 5.2 Эмчлүүлэгчдийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаарх холбогдох бичиг баримт (эмнэлгийн чөлөө олгох хуудас, магадалгаа, эмнэлгээс гаргагчийн дүгнэлт г м)-ыг үнэн зөв хөтөлж, цахим бүртгэл болон статистик дүн бүртгэлд тогтмол мэдээлнэ.
- 5.3 Үйлчлүүлэгчийн дунд өөрийгөө дур мэдэн эмчилж, хүндрүүлэх, нэн яаралтай шийдвэр гаргах нөхцөлд цаг алдах, эмчийн заавар, эмчилгээний дэглэмийг биелүүлээгүйгээс гарч болох хүндрэл, эрсдэлийг урьдчилан таниулах,

- хүндрэлээс сэргийлэхэд эмчлүүлэгч, түүний ар гэрийнхний үүрэг, хариуцлагыг сурталчилж, мэдээлнэ.
- 5.4 Өвчний шинж тэмдгээ хэрхэн ажиглаж, гэрийн нөхцөлд ямар арга хэмжээ авах, ямар тохиолдолд эмнэлэгт хандах, илгээх бичгийг хаанаас авах, эмнэлэг, эмчээ зөв сонгох, эмнэлгээс гарсны дараа хаана хандах гэх мэт асуудлаар хариуцлагатай, нотолгоонд тулгуурласан зөв шийдвэр гаргахад нь иргэнд туслах зорилгоор зураг, дүрслэл бүхий хялбаршуулсан мэдээллийг цахим болон цаасан хэлбэрээр гаргаж, хүргэнэ.
- 5.5 Эмчлүүлэгчдэд сэтгэцийн болон эрүүл мэндийн боловсрол олгох, архаг өвчний сэдрэлээс урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар сургалт, сурталчилгаа явуулна.
- 5.6 Эмчлүүлэгч тэднийг асуулт асуух, мэдээлэл авах эрхийг хангаж, үйлчлүүлэгчтэй хүндэтгэж харилцах соёлыг хэвшүүлж ажиллана.
- 5.7 Клиникт ашиглагдаж байгаа оношилгооны тоног төхөөрөмжийн техникийн аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлан ажиллаж, төхөөрөмжийн цаг ашиглалтын паспортыг тогтмол хөтөлж, баталгаат үзлэгт хамруулна.
- 5.8 Эмнэлгээс шалтгаалсан халдвараас урьдчилан сэргийлж халдварын сэргийлэл хяналтыг чанд баримтлан, эмчлүүлэгчид эрүүл аюулгүй орчинд тусламж үйлчилгээ авах бүхий л бололцоо нөхцөлөөр хангаж ажиллана.
- 5.9 Клиникийн эмч мэргэжилтнүүд нь бусдыгаа орлох ба бусад алба, нэгжүүдтэйгээ холбоотой ажиллаж мэргэжлийн болон бусад үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцоно.
- 5.10 Төр хариуцан төлж буй тусламж, үйлчилгээ болон, төлбөртэй тусламж, үйлчилгээний нэр төрөл, төлбөрийн хэмжээ зэргийг үйлчлүүлэгчдэд ил тод мэдээлэл өгч, албан бус төлбөрөөс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.

Журам боловсруулсан:

ЭМЧИЛГЭЭ ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ  Н.ОЮУНЧИМЭГ



ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ШААРДЛАГАТАЙ СЭТГЭЦИЙН ЭМГЭГИЙН ЖАГСААЛТ

1. Ухаан балартах хамшинж
2. Хий үзэгдлийн хамшинж
3. Дэмиёрлийн хамшинж
4. Кататонийн хамшинж
5. Гебоид хамшинж
6. Сэтгэцийн автоматчлал
7. Гэнэтийн өөрийн мэдэлгүй үйлдлүүд
8. Гэнэтийн эмгэг дур
9. Сэтгэл гутралын хамшинж
10. Сэтгэл хөөрлийн хамшинж
11. Хий үзэгдэл дэмиёрлийн хамшинж
12. Сэтгэц хөдөлгөөний дошгирол
13. Кандинский - Клерамбогийн хамшинж
14. Кататоник дошгирол
15. Хүүхдэрхэх дошгирол
16. Эмгэг төрхийн дошгирол
17. Бухимдлын дошгирол
18. Эпилепсийн дошгирол
19. Оюуны хомсдол эмгэгийн дошгирол
20. Халууралттай хэлбэрийн шизофрени
21. Архины шалтгаант солиорол
22. Амиа хорлох оролдлого хийсэн /амиа хорлохыг завдсан/
23. Ухаан дэмиёрэн балартах хамшинж
24. Ухаан зүүдчилэн балартах хамшинж
25. Ухаан будангуйран балартах хамшинж
26. Ухаан бүрийтэн балартах хамшинж
27. Ухаан нойрмоглохон балартах хамшинж
28. Сэтгэцэд нөлөөт эмийн хордлогын хамшинж, гаж нөлөө
29. Нийгэмд аюултай үйлдэл хийх магадлалтай сэтгэцийн бусад эмгэг

СТАЦИОНАРТ ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ КЛИНИКИЙН ХУВААРИЛАЛТ

Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ:

1. Сэтгэцийн эмгэг судлалын I клиникт:

- Сэтгэцийн хурц хэлбэрийн эмгэгтэй анх удаа хэвтэн эмчлүүлж буй тохиолдолд харьяалал харгалзахгүйгээр

Жич: Сэтгэцийн архаг эмгэгтэй төгсгөлийн үе шатанд орсон, оюуны хомсдол, янз бүрийн шалтгаант тэнэгрэл, солиорол, ухамсарт ухаан бүрийтэн балартал, зан үйлийн өөрчлөлт бүхий уналттай, сэтгэцийн эмгэгийн улмаас орон нутагтаа удаа дараа хэвтэн эмчлүүлж байсан эмчлүүлэгчдэд хамаарахгүй.

2. Сэтгэцийн эмгэг судлалын II клиникт:

- Сонгинохайрхан дүүрэг, (Сэтгэцийн удаан хугацааны хэвтэн эмчлүүлэгч харьяалал харгалзахгүйгээр)

3. Сэтгэцийн эмгэг судлалын III клиникт:

- Чингэлтэй, Сүхбаатар, Багануур дүүрэг, Говьсүмбэр, Хөвсгөл аймаг

4. Сэтгэцийн эмгэг судлалын IV клиникт:

- Баянгол, Хан-Уул дүүрэг, Говь-Алтай, Увс, Хэнтий аймаг

5. Сэтгэцийн эмгэг судлалын V клиникт:

- Баянзүрх, Налайх, Багахангай дүүрэг, Баян-Өлгий, Ховд аймаг

6. Сэтгэцийн эмгэг судлалын VI клиникт:

- Архангай, Баянхонгор, Булган, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Төв, Сүхбаатар, Сэлэнгэ аймаг

Жич: Клиникүүд Коронавирусын халдвар Ковид – 19 цар тахал өвчний нөхцөл байдлаар өөрчлөгдөж болно.

Төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ

1. Стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын клиникт:

- Стрессийн шалтгаант сэтгэл түгших, айдас, дасан зохицохуйн болон архаг ядаргаа /сульдлын, ялимгүй зовлонт байдлын, истери/ эмгэгтэй эмчлүүлэгч харьяалал харгалзахгүйгээр, төлбөртэй

Жич: Мэдрэлийн болон биеийн хүнд эмгэгтэй, бусад эрхтэн тогтолцооны дутагдалд орсон, артерийн даралт ихдэх эмгэгтэй эмчлүүлэгчдэд хамаарахгүй.

2. Хүүхэд, өсвөр үеийн сэтгэцийн эмгэг судлалын клиникт:

- Сэтгэцийн болон зан үйлийн эмгэгтэй 3-14 насны хүүхэд, 15-17 насны өсвөр үеийнхэн харьяалал харгалзахгүйгээр

Жич: Клиникүүд Короновирусын халдвар Ковид – 19 цар тахал өвчний нөхцөл байдлаар өөрчлөгдөж болно.

5. Донтох эмгэг судлалын клиникт:

- Архи болон мансууруулах эм, бодист донтох эмгэг, архи болон сэтгэц идэвхт бодисын шалтгаант хордлого, хараат байдлын хам шинж, шарталтын хам шинж, шарталтын ухаан дэмийрэн баларталт бүхий солиорол бүхий эмчлүүлэгч харьяалал харгалзахгүйгээр, төлбөртэй

6. Яаралтай тусламжийн тасагт:


- Сэтгэцийн болон биеийн байдал хүндэрч эрчимт эмчилгээ хийх тохиолдолд
- Сэтгэцэд нөлөөт эмийн хүнд хэлбэрийн хордлого
- Өвчний оношийг богино хугацаанд тогтоох боломжгүй, үйлчлүүлэгчийн биеийн байдал маш хүнд, нэр, хаяггүй, баримт бичгийн бүрдэлгүй тохиолдолд
- Үйлчлүүлэгчийн биеийн байдал нь эмнэлгийн нөхцөлд ажиглалт хийх шаардлагатай тохиолдолд
- Сэтгэцийн зарим эмгэгийн хөнгөн хэлбэрийн эмгэгтэй эмчлүүлэгч харьяалал харгалзахгүйгээр, төлбөргүй
- Сэтгэл түгших, айдас, дасан зохицохуйн болон архаг ядаргаа /сульдлын, ялимгүй зовлонт байдлын, истери/ эмгэгтэй эмчлүүлэгч харьяалал харгалзахгүйгээр, төлбөртэй

7. “Сэтгэц Ковид – 19” тасагт:

Антигенд суурилсан түргэвчилсэн сорил бүхий шинж тэмдэгтэй болон бодит хугацааны ПГУ-ын шинжилгээгээр Ковид-19 халдвартай нь батлагдсан сэтгэцийн эмгэгтэй эмчлүүлэгчийг төлбөргүйгээр

8. Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникт:

- Шүүхийн тогтоолоор албадан эмчилгээ заагдсан эмчлүүлэгч
- Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадалгааг стационарын нөхцөлд хийлгэх тогтоолтой үйлчлүүлэгч
- ШШГЕГ-ын харьяа хорих ангиудад ял эдлэх хугацаанд сэтгэцийн хурц солиорлоор өвчилсөн эмчлүүлэгч



МАГАДЛАН ТОГТООХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН


Комиссын дарга:	Н.Оюунчимэг	Эмчилгээ эрхэлсэн дэд захирал
Нарийн бичгийн дарга	Г.Уянга	Чанарын менежер
Гишүүд:	Д.Лянхуа	Зөвлөх эмч
	Л.Мөнхтуяа	Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч эмч
		Тасгийн эрхлэгч нар

**ХАМТАРСАН ҮЗЛЭГ, ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ХАРИУЦАН АХАЛЖ
 АЖИЛЛАХ УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД,
 ЗӨВЛӨХ ЭМЧ НАРЫН ХУВААРЬ**

№	Овог нэр	Албан тушаал	Хариуцсан клиник, тасаг
1. ХАМТАРСАН ҮЗЛЭГ АХЛАХ			
1	Д.Лянхуа	Зөвлөх эмч	Сэтгэцийн эмгэг судлалын 1-6 клиник
2	Г.Доржханд	Зөвлөх эмч	Стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын клиник, Донтох эмгэг судлалын клиник, Асрамжийн клиник
3	О.Баатаржав	Стратеги төлөвлөлт, хүний нөөц эрхэлсэн дэд захирал	Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиник, Сэтгэцийн эмгэг судлалын бусад клиникт шүүхийн тогтоолоор хэвтэн эмчлүүлж байгаа эмчлүүлэгчид
2. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ХАРИУЦАН АХЛАЖ АЖИЛЛАХ УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД			
1	Л.Насанцэнгэл	Ерөнхий захирал	Асрамжийн клиник, Донтох эмгэг судлалын клиник
2	Н.Оюунчимэг	Эмчилгээ эрхэлсэн дэд захирал	Яаралтай тусламжийн тасаг Өдрийн эмийн эмчилгээ, Сэргээн засах эмчилгээний тасаг, Сэтгэц Ковид – 19 тасаг
3	В.Баярмаа	Нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, сургалт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал	Поликлиник, Стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын клиник
4	О.Баатаржав	Стратеги төлөвлөлт, хүний нөөц эрхэлсэн дэд захирал	Сэтгэцийн эмгэг судлалын 1,2,3 клиник, Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиник
5	Д.Одончимэг	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дарга	Сэтгэцийн эмгэг судлалын 4,6 клиник, Донтох эмгэг судлалын клиник,
6	Д.Дэжидмаа	Поликлиникийн эрхлэгч	Поликлиник, Сэтгэцийн эмгэг судлалын 5 клиник

**УЛААНБААТАР ХОТЫН ЭМНЭЛЭГ, ТӨВҮҮДЭД
СЭТГЭЦИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ЭМЧ НАРЫН ХУВААРЬ**

№	Эмнэлэг төвүүд	Зөвлөгөө өгөх эмч нар	Холбогдох утасны дугаар
1	Улсын нэгдүгээр төв эмнэлэг /УНТЭ/	Л.Мөнхтуяа Г.Уянга С.Мөнхтуяа	91994628 99756762 99163697
2	Улсын хоёрдугаар төв эмнэлэг /УХТЭ/	Д.Лянхуа Г.Нарантуяа К.Елена	99297902 99120163 99232367
3	П.Н.Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг /УГТЭ/	Б.Туяа Б.Соёлмаа П.Долгор	99097335 99946200 99237657
4	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /ЭХЭМҮТ/-ийн төрөх клиник	Д.Эрдэнэсүвд Ц.Саранцацрал З.Цэндсүрэн	91575797 99261617 89117994
5	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /ЭХЭМҮТ/-ийн хүүхдийн клиник	Л.Цэрэндолгор Т.Саранцэцэг П.Энхчимэг	88019707 91881169 99220062
6	Хүүхдийн төв сувилал /ХТС/	Т.Энхсайхан	99942810
7	Хавдар судлалын үндэсний төв /ХСҮТ/	Э.Мөнх Г.Гантулга	91111094 99804895
8	Халдварт өвчин судлалын үндэсний төв /ХӨСҮТ/	Б.Алтанзул Ш.Одончимэг	88074737 96186848
9	Гэмтэл согог судлалын үндэсний төв /ГССҮТ/	Л.Баттулга Б.Мөнх-Эрдэнэ Б.Бөхбат	96113010 99689661 88080680
10	Арьсны өвчин судлалын үндэсний төв /АӨСҮТ/	Б.Энхтайван Х.Эрхцэцэг	99990063 95662141
11	Цэргийн төв эмнэлэг /Хордлогын төв/	Б.Энхчимэг Д.Баттөр	99993418 99158103
12	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	Л.Насанжаргал А.Лхамжаргал	88012009 90195499
13	Хорихын нэгдсэн эмнэлэг	С.Байгалмаа Я.Ганхүү	99024803 99883005
14	“Өргөө”, “Хүрээ”, “Амгалан” амаржих газар	Б.Энх-Ундрах Б.Оюунтуяа Б.Батцэцэг	98109888 95969770 90198424
15	Хувийн хэвшлийн эмнэлэг (Интермед, Грандмед, УБ Сонгдо ба бусад)	Н.Эрдэнэтуул Ш.Сугармаа	99177540 91026090



**НИЙСЛЭЛИЙН ДҮҮРЭГ, ОРОН НУТАГТ СЭТГЭЦИЙН МЭРГЭЖЛИЙН
 ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ЭМЧ НАРЫН ХУВААРЬ**

№	Дүүрэг, аймгийн нэр	Зөвлөгөө өгөх эмч нарын нэр	Албан тушаал
Нийслэлийн дүүрэг			
1	Багануур	Ц.Саранцацрал	Баянзүрх дүүргийн үзлэгийн эмч
2	Багахангай	П.Энхчимэг	Сүхбаатар дүүргийн үзлэгийн эмч
3	Баянгол	П.Долгор	СЭС-ын I клиникийн үзлэгийн эмч
4	Баянзүрх	Б.Энхтайван	СЭС-ын VI клиникийн үзлэгийн эмч
5	Налайх	Б.Соёлмаа	Донтох эмгэг судлалын үзлэгийн эмч
6	Сонгинохайрхан	Д.Баттөр	Донтох эмгэг судлалын үзлэгийн эмч
7	Сүхбаатар	Л.Насанжаргал	Донтох эмгэг судлалын үзлэгийн эмч
8	Хан-Уул	З.Цэндсүрэн	Поликлиникийн эмч
9	Чингэлтэй	Т.Саранцэцэг	Асрамжийн клиникийн үзлэгийн эмч
Орон нутаг			
1	Архангай	Г.Нарантуяа	СЭС-ын I клиникийн эрхлэгч
2	Баян-Өлгий	Э.Амгалан	СЭС-ын V клиникийн эрхлэгч
3	Баянхонгор	Ц.Цэрэнмөнх	СЭС-ын VI клиникийн эрхлэгч
4	Булган	Л.Цэрэндолгор	ХӨҮ-ийн клиникийн эрхлэгч
5	Говь-Алтай	З.Ганзориг	СЭС-ын IV клиникийн эрхлэгч
6	Говьсүмбэр	Я.Сампил	Асрамжийн клиникийн эрхлэгч
7	Дархан-Уул	Д.Дэжидмаа	Поликлиникийн эрхлэгч
8	Дорноговь	Н.Эрдэнэтуул	СЗФЭ-ний тасгийн эрхлэгч
9	Дорнод	Б.Энхчимэг	ДЭС-ын клиникийн эрхлэгч
10	Дундговь	Б.Туяа	Сэтгэл зүйн оношилгооны багийн ахлагч
11	Завхан	В.Баярмаа	Нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, сургалт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал
12	Орхон	Н.Оюунчимэг	Эмчилгээ эрхэлсэн дэд захирал
13	Өвөрхангай	Л.Мөнхтуяа	Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч
14	Өмнөговь	Э.Мөнх	Сэтгэл засал эмчилгээний багийн ахлагч
15	Сүхбаатар	Д.Одончимэг	Чанарын албаны дарга
16	Сэлэнгэ	С.Одонгэрэл	ШСЭС-ын клиникийн эрхлэгч
17	Төв	С.Байгалмаа	ШСЭС-ын клиникийн эрхлэгч
18	Увс	Г.Уянга	Чанарын менежер
19	Ховд	О.Баатаржав	Стратеги төлөвлөлт хүний нөөц эрхэлсэн дэд захирал
20	Хөвсгөл	Б.Долгормаа	СЭС-ын III клиникийн эрхлэгч
21	Хэнтий	Б.Алтанзул	СЭС-ын II клиникийн эрхлэгч

**БУСАД ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ
 ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ, ХУВААРЬ**

№	Байгууллагын нэр	Тусламж, үйлчилгээний чиглэл
1	Арьсны өвчин судлалын үндэсний төв	<ul style="list-style-type: none"> - Арьс, арьсан доорх эслэгийн өвчний тусламж, үйлчилгээ - Арьсны харшил өвчний тусламж, үйлчилгээ - Арьсны өвчний мэс заслын тусламж, үйлчилгээ
2	Гэмтэл, согог судлалын үндэсний төв	<ul style="list-style-type: none"> - Гэмтэл, согогийн тусламж, үйлчилгээ - Хүүхдийн гэмтэл, согогийн тусламж, үйлчилгээ - Гэмтэл, согогийн мэс заслын тусламж, үйлчилгээ - Түлэнхий, осголт, хөлдөлтийн тусламж, үйлчилгээ - Гэмтэл согогийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ
3	Халдварт өвчин судлалын үндэсний төв	<ul style="list-style-type: none"> - Халдварт өвчин судлалын тусламж, үйлчилгээ - Сүрьеэ өвчин судлалын тусламж, үйлчилгээ - Халдвар судлалын лабораторийн тусламж, үйлчилгээ
4	Хавдар судлалын үндэсний төв	<ul style="list-style-type: none"> - Бүх төрлийн хавдрын тусламж, үйлчилгээ - Хүүхдийн хавдрын тусламж, үйлчилгээ
5	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн дотор, мэс заслын чиглэлийн бүх төрлийн төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ - Хүүхдийн нүд, чих хамар хоолойн тусламж үйлчилгээ - Хүүхдийн мэдрэл судлалын тусламж үйлчилгээ - Хүүхдийн харшил судлалын тусламж, үйлчилгээ - Эмэгтэйчүүдийн өвчний тусламж, үйлчилгээ - Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн тусламж үйлчилгээ - Эрсдэлтэй жирэмсэн, дутуу тээлт, дутуу төрөлтийн тусламж, үйлчилгээ
6	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	<ul style="list-style-type: none"> - Цус, цус төлжүүлэх эрхтэн тогтолцооны эмгэгийг, тусламж, үйлчилгээ - Дархлааны механизм хамарсан эмгэгийн тусламж, үйлчилгээ - Дотоод шүүрэл, шим тэжээл, бодисын солилцооны эмгэгийн тусламж, үйлчилгээ - Яаралтай тусламж, мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээ - Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны тусламж, үйлчилгээ - Эрүү, нүүрний мэс заслын тусламж, үйлчилгээ - Шээс, бэлгийн тогтолцооны эмгэгийн тусламж, үйлчилгээ - Яс, үе, булчингийн тогтолцоо, холбох эдийн эмгэгийн тусламж, үйлчилгээ - Нүдний тусламж, үйлчилгээ - Чих, хамар, хоолойн тусламж, үйлчилгээ - Цусны хавдрын тусламж үйлчилгээ - Цөмийн анагаах ухааны оношилгоо, эмчилгээний

		тусламж, үйлчилгээ
7	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	- Дүрс оношилгоо - Позитрон цацрагийн оношилгоо, эмчилгээ, хяналт (ПЭТ-КТ)
8	Улсын гуравдугаар төв эмнэлэг	- Зүрх судасны өвчний тусламж, үйлчилгээ - Зүрхний мэс заслын тусламж, үйлчилгээ - Судсанд дотуурх мэс засал, ангиографийн тусламж, үйлчилгээ - Мэдрэлийн тогтолцооны өвчний тусламж, үйлчилгээ - Тархи, нуруу нугасны мэс заслын тусламж, үйлчилгээ - Амьсгалын тогтолцооны өвчний тусламж, үйлчилгээ - Цээжний хөндийн мэс заслын тусламж, үйлчилгээ
9	Цэргийн төв эмнэлэг	- Эм, химийн бодисын хордлогын тусламж, үйлчилгээ - Цацраг идэвхт бодис, бактерийн хордлогын тусламж, үйлчилгээ - Хутга, мэс, галт зэвсгийн гэмтлээс шалтгаалсан гэмтлийн тусламж, үйлчилгээ - Мэс заслын тусламж, үйлчилгээ
10	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	- Зоонозын өвчний тусламж, үйлчилгээ
11	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	- Цус сэлбэлт судлалын тусламж, үйлчилгээ
12	Эмгэг судлалын үндэсний төв	- Эмгэг судлалын тусламж, үйлчилгээ
13	Геронтологийн үндэсний төв	- Настны эмгэг судлалын тусламж, үйлчилгээ